# PISA 2025

## ҮНДСЭН СУДАЛГАА

## ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН




2025.12.05

# АГУУЛГА

**1 БЭЛТГЭЛ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 4**
1.1 Эрх зүйн үндэслэл ..... 4
1.2 Даалгавар, асуулга эцэслэх үйл ажиллагаа ..... 7
1.1 Түүврийн загвар, сургууль, сурагчдын түүвэр ..... 11
1.2 Холбогдох сургалтууд ..... 16
1.5 Зохион байгуулалтын бэлтгэл үйл ажиллагаа ..... 18
**2 ҮНДСЭН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..... 22**
2.1 Үнэлгээний хэрэгслийн тухай ..... 22
2.2 Хяналт мониторинг ..... 22
2.3 Зохион байгуулах баг ..... 23
**3 ДААЛГАВАР, АСУУЛГА КОДЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 24**
3.1 Даалгавар кодлох үйл ажиллагаа ..... 25
3.2 Эцэг эх асран хамгаалагчийн асуулга кодлох үйл ажиллагаа ..... 28
3.3 Ажил мэргэжлийг кодлох үйл ажиллагаа ..... 29
**4 ДАТА ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ..... 30**
Алхам 1: 2025 оны 6-р сар ..... 31
Алхам 2: 2025 оны 7-р сар ..... 31
Алхам 3: 2025 оны 9-р сар ..... 33
Алхам 4: 2025 оны 11-р сар ..... 34

**Зургийн жагсаалт**

Зураг 1. Даалгавар, орчуулах, хянах, формат эцэслэх гол алхмууд.................................... 8
Зураг 2. Үндсэн судалгаанд ашиглагдсан даалгавар тоо ..................................................... 8
Зураг 3. Сургалтын танилцуулга мэдээлэл ........................................................................... 9
Зураг 4. Үндсэн судалгаанд ашиглагдсан асуулгын тоо ....................................................... 9
Зураг 5. Цахим шалгалт дэвтэрлэх процесс ........................................................................10
Зураг 6. Түүврийн даалгаврын ерөнхий алхам .....................................................................11
Зураг 7. Түүрийн даалгаврын ажлын болон үндсэн судалгааны Westat багтай файл солилцох талбар..................................................................................................................14
Зураг 8. Ажлын даалгаврын зөвлөгөө авч буй байдал/жишээ зураг ....................................15
Зураг 11. Үнэлгээ зохион байгуулах маршрут, хуваарь.........................................................19
Зураг 12. PISA лого бүхий дурсгалын зүйлс...........................................................................21
Зураг 13. Шалгалтын явцын зурагнуудаас .............................................................................24
Зураг 14. Даалгавар, асуулга кодлох, дата цэвэрлэх үе шат, хугацаа .................................24
Зураг 15. Кодлох программын харагдах байдал, архивласан байдал ..................................29
Зураг 16. Ажил,мэргэжлийн кодлолтыг хийсэн ажлын хуудас ..............................................30
Зураг 17. Дата цэвэрлэгээний ажлын төлөвлөгөө ................................................................30
Зураг 18. Ажлын файлын жишээ .............................................................................................32
Зураг 19. Даалгаврын дата чек................................................................................................33

**Хүснэгтийн жагсаалт**

Хүснэгт 1. Үндэсний багийн зохион байгуулалт ...................................................................... 4
Хүснэгт 2. Үйл ажиллагааны зураглал........................................................................................ 5
Хүснэгт 3. Үйл ажиллагааны төлөвлөгөө ................................................................................... 5
Хүснэгт 4. Үнэлгээнд ашиглагдсан үндсэн программ/платформ............................................. 7
Хүснэгт 5. Үйл ажиллагааны нэгтгэл .........................................................................................12
Хүснэгт 6. Түүврийн даалгавруудын агуулга.............................................................................13
Хүснэгт 7. БҮТ/ Үндэсний төвөөс зохион байгуулсан сургалтын жагсаалт ...........................16
Хүснэгт 8. Боловсруулсан баримт бичгийн жагсаалт ..............................................................20
Хүснэгт 9. Олон нийтэд таниулцах шторкууд............................................................................20
Хүснэгт 10. Зохион байгуулалтын багийн тоо ..........................................................................23
Хүснэгт 11. Нийт сургуулиудын ирц, оролцоо ..........................................................................23
Хүснэгт 12. Асуулга кодлолтын багийн ажлын гүйцэтгэл /Хүснэгт 1/ ...................................28

# 1 БЭЛТГЭЛ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 1.1 Эрх зүйн үндэслэл

Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ (PISA-2025)-г үндэсний хэмжээнд 2024.03.07-2024.05.05-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 35.6 дугаар зүйлд “Боловсролын чанарыг гурван жил тутам олон улсын эрх бүхий байгууллагаар үнэлүүлнэ” гэж заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ЭЗХАХБ болон МУ-ын БШУЯ “Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ (PISA) 2025 үнэлгээнд хамрагдах тухай” гэрээг байгуулсан.
Монгол Улс 2022 онд анх удаа PISA үнэлгээнд хамрагдсан бөгөөд үүний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр “Олон улсын PISA-2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн Газрын 105-р тогтоол батлагдсан ба 1.5-р зүйлд 2025 онд дахин хамрагдах бэлтгэл хангахыг заасан.

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тушаалаар “Олон улсын PISA-2025 үнэлгээний бэлтгэх хангах, зохион байгуулах тухай Боловсролын сайдын албан даалгавар, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны “Сурлагын амжилтын олон улсын үнэлгээ /PISA-2025/ зохион байгуулах, үндэсний багийн бүрэлдэхүүн, төлөвлөгөө, төсөв батлах тухай” БҮТ-ийн захирлын А/06 дагуу Үндсэн судалгааг зохион байгууллаа.

PISA үнэлгээний Үндэсний төв/National Center нь БҮТ дээр байх бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй (үндсэн 36 гишүүн) байгуулсан. Багийн гишүүдийн 90% нь 2022 оны цикл болон туршилтын судалгаанд ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд юм.

Хүснэгт 1. Үндэсний багийн зохион байгуулалт



Хүснэгт 2. Үйл ажиллагааны зураглал




Хүснэгт 3. Үйл ажиллагааны төлөвлөгөө

| | Үйл ажиллагаа | 8/19 | 8/26 | 9/2 | 9/9 | 9/13 | 9/15 | 9/16 | 9/19 | 09/25-09/28 | 10/01-10/02 | 10/05-10/30 | 11/01-11/05 | 11/05-11/30 | 12/01-12/15 | 12/11 | 12/15 | 12/30 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ДС даалгаврын шинжилгээ хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | АС баг асуулгын шинжилгээ хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | 2-р хагас жилийн төлөвлөгөө эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | NPM PISA Connect Workflow дээр ажиллах | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Сургууль, багшийн асуулга-TC анализ дээр ажиллах | | Асуулгын нийцлийг хянах, орчуулга, найруулга эцэслэх | | | | | | | | | | | | | | | |
| 6 | Сурагч, эцэг эхийн асуулга-TC анализ дээр ажиллах | | Асуулгын нийцлийг хянах, орчуулга, найруулга эцэслэх | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Даалгаврын анализ хийж, сайжруулах шаардлагатай үг, өгүүлбэрийг тогтоох-Тестийн баг бүгд | | | | | | Эцэсл эж | | | | | | | | | | | |
| 8 | Газар хөдлөлт даалгавар-Тодруулга авах | | | | | | | мэйл илгээ | | | | | | | | | | |
| 9 | Тренд даалгаврын layout-ыг шалгах-Тестийн баг бүгд | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Сургууль, багшийн асуулга-сайжруулах | | | | | | | | | | | | | | | | | |
| 11 | Сурагч, эцэг эхийн асуулга-сайжруулах | | | | | | | | | | | | | | | | | |
| 12 | Үнэлгээний гарын авлагуудыг орчуулах, хянах, эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 13 | Түүврийн даалгаврууд/ ST 5, 6 | | | | | | | | | | | | | | | | | |
| 14 | PISA дотоодын цахим шалгалтын сэдэв, даалгавар бэлдэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 15 | PISA цахим шалгалт зохион байгуулах сургалт зохион байгуулах | | | | | | | | | | | | | | | | | |
| 16 | PISA цахим шалгалт зохион байгуулах | | | | | | | | | | | | | | | | | |
| 17 | PISA цахим шалгалтыг үр дүнд анализ хийх | | | | | | | | | | | | | | | | | |
| 18 | PISA цахим шалгалтын ЗБ тайлан бичих | | | | | | | | | | | | | | | | | |
| 19 | PISA цахим шалгалтын ҮР ДҮН-гийн тайлан бичих | | | | | | | | | | | | | | | | | |
| 20 | Гарын авлагуудын англи хувилбарт update хийх, эцэслэх-SMAF | | | | | | | | | | | | | | | | | |
| 21 | Гарын авлагуудын монгол хувилбарыг эцэслэх-SMAF | | | | | | | | | | | | | | | | | |
| 22 | Сурагчийн асуулга казах орчуулга эцэслэх/ OmegaT | | | | | | | | | | | | | Орчуулагч | | | | |
| 23 | Эцэг эхийн асуулга казах орчуулга эцэслэх/ OmegaT | | | | | | | | | | | | | Орчуулагч | | | | |
| 24 | Түүврийн даалгаврууд/ ST 7AB, 8AB | | | | | | | | | | | | | | | | | |
| 25 | Асуулгын layout эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 26 | Даалгаврын layout эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 27 | Түүврийн даалгавар 9A | | | | | | | | | | | | | | | | | |
| 28 | Мониторинг-PISA NQM-нэгдсэн- мэргэжилтэн санал болгох | | | | | | | | | | | | | | | | | |
| 29 | Түүврийн сургалт/ MAPLE сургалтад цахимаар хамрагдах | | | | | | | | | | | | | | | | | |
| 30 | Сургуулийн түүврийг эцэслэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 31 | Үндэсний багийн бүтэц батлах тушаал/төсөв | | | | | | | | | | | | | | | | | |
| 32 | Үндсэн судалгааны төлөвлөгөө/ хуваарь батлах | | | | | | | | | | | | | | | | | |
| 33 | Үндэсний багийн гэрээ хийгдэх | | | | | | | | | | | | | | | | | |
| 34 | Мониторинг-PISA NQM-нэгдсэн-ACER сонгох/ сургах/ хуваарь хийх | | | | | | | | | | | | | | | | | |

| | Үйл ажиллагаа | 2025.01.05-01.20 | 12.12-12.17 | 12.19-12.31 | 01.01-01-31 | 01.06-01.13 | 01.27-01.30 | 02.03-02.05 | 02.10-02.13 | 02.18 | 02.25 | 02.26 | 03.04 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | Мониторинг-PISA NQM-нэгдсэн-ACER сонгох/ сургах/ хуваарь хийх | ACER хийх | | | | | | | | | | | |
| 35 | 191 сургуулийн 15 настнуудын датаг татах/ шалгах сургуулиар нь хувааж бэлдэх | | | | | | | | | | | | |
| 36 | БГ-үүдад сургалт орох- мэдээлэл өгөх -191 сургуультай холбогдож, сурагчийн датаг эцэслэх- АСУУЛГЫГ ЯМАР ХЭЛЭЭР БӨГЛҮҮЛЭХИЙГ АВАХ- МОНГОЛ, КАЗАХ? -Стандарт 6.3-8 долоо хоногийн өмнө | | | | | | | | | | | | |
| 37 | Сурагчийн датаг MAPLE-д оруулж, сурагчийн түүврийг эцэслэх | | | | | | | | | | | | |
| 38 | Сурагч, багш, сургуулийн маягтуудыг гаргаж бэлтгэх | | | | | | | | | | | | |
| 39 | Асуулгын ppt бэлтгэх, эцэслэх | | | | | | | | | | | | |
| 40 | Кодлох гарын авлагын орчуулгад update хийх | | | | | | | | | | | | |
| 41 | Кодлох гарын авлагын орчуулгыг шалгаж, эцэслэх | | | | | | | | | | | | |
| 42 | Асуулга кодлох сургалт | | | | | | | | | | | | |
| 43 | Сургалт зохион байгуулах-БГ, БХ+ Захирлууд | | | | | | | | | ХОТ | | | |
| 44 | Сургалт зохион байгуулах-ЗБ-үүдэд+Захирал/ Менежер | | | | | | | | | | хөдөө | | |
| 45 | Мониторинг-PISA NQM-дотоод- сонгох/ хуваарь гаргах | | | | | | | | ACER хийх | | | | |
| 46 | Мониторинг-PISA NQM-сургалт хийх | | | | | | | | ACER хийх | | | | |
| 47 | Комиссын гэрээ хийгдэх | | | | | | | | | | | | |
| 48 | Сургалт зохион байгуулах-Хянагч багшид-Түрүүлж дууссан сурагчдад ямар материал өгөх талаар brainstorm хийх | | | | | | | | | | | | |
| 49 | Сургалт зохион байгуулах-IT менежерт | | | | | | | | | | | | |
| 50 | PISA2025-ын постер дээр ажиллах | | | | | | | | | | | | |
| 51 | Видео шторк хийх/ Шалгалтын бэлтгэл хангаж үзүүлэх, сургуулиудад үзүүлэх | | | | | | | | | | | | |
| 52 | Кодлох сургалтад хамрагдах-БУ | | | | | | | | | | | | |
| 53 | Кодлох сургалтад хамрагдах-Мат | | | | | | | | | | | | |
| 54 | Кодлох сургалтад хамрагдах-Унших | | | | | | | | | | | | |
| 55 | Эцэг эхийн асуулгыг ворд-оор татаж авч хэвлэлтэд бэлдэх-File Exchange-ээс татаж авах | | | | | | | | | | | | |
| 56 | Эцэг эхийн асуулгыг хэвлэж, эцэслэх | | | | | | | | | | | | |

| | Үйл ажиллагаа | 03.05-03.28 | 04.01 | 04.14-05.09 | 05.09-05.23 | 05.12 | 05.13-05.30 | 05.19-06.13 | 06.13-07.10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 57 | Үндсэн судалгаа-хот | ҮС-ХОТ | | | | | | | |
| 58 | Эцэг эхийн асуулгыг орон нутагт шуудангаар илгээх | | | | | | | | |
| 59 | Үндсэн судалгаа-орон нутаг | | | ҮС-ОРОН НУТАГ | | | | | |
| 60 | Ирцийн хуудсыг өдөр өдөртөө хариуцсан мэргэжилтэнд явуулах | | | | | | | | |
| 61 | Шалгалт аваад дууссаны дараа Асуулгын баг ХБ-ын протоколыг нэгтгэх | | | | | | | | |
| 62 | Ажил мэргэжлийн кодлолтын ажлын хуудсуудыг хүлээн авах | | | | 5.09 | | | | |
| 63 | Ажил мэргэжлийн кодлолтын сургалт орох | | | | | 5.12 | | | |
| 64 | Ажил мэргэжлийн кодлолт | | | | | | | | |
| 65 | Даалгавар кодлох-БУ | | | | | | | | |
| 66 | Даалгавар кодлох-Мат | | | | | | | | |
| 67 | Даалгавар кодлох-Унших чадвар | | | | | | | | |
| 68 | Эцэг эхийн асуулга кодлох | | | | | | | | |
| 69 | Дата цэвэрлэгээ- Stage 1 | | | | 05.09-05.23 | | | | |
| 70 | Дата цэвэрлэгээ- Stage 2 | | | | | 05.26-06.06 | | | |
| 71 | Дата менежер/домайн менежер/тестийн багийн ахлагчид бэлэн байх | | | | | | | 06.06-07.01 | |

PISA үнэлгээний 2025 оны циклийн үндсэн туслан гүйцэтгэгч болох Австрали улсын ACER боловсролын үнэлгээний байгууллагын чиглүүлэг, удирдамжийн үнэлгээг зохион байгууллаа. Туслан гүйцэтгэх байгууллагууд чиг үүргээсээ хамаарч олон төрлийн программ хангамж, платформ ашигласан бөгөөд багийн гишүүд өөрсдийн логин, нууц үгээр нэвтэрч тус бүрийн даалгаврыг гүйцэтгэж ажилласан.

Хүснэгт 4. Үнэлгээнд ашиглагдсан үндсэн программ/платформ

| № | Платформ/ программын нэр | Зориулалт |
|---|---|---|
| 1 | Pisa Connnect | Оролцогч бүх улс орнууд ханддаг, зар мэдээлэл, гарын авлага материалууд байршихаас гадна асуулт, тусламж шаардлагатай тохиолдолд Helpdesk дээр бичиж ханддаг. Preview-даалгавар харах, Helpdesk-мэйл бичих, Documents-гарын авлага, материал байрших, File Exchange-шаардлагатай файлууд, кодууд байрших, Workflow-даалгаврууд тавигдах гм.олон цэстэй. |
| 2 | TAO | Шалгалтын платформ- сурагч, сургууль үнэлгээ, асуулгад хамрагдах, dashboard-буюу төвөөс хянах платформ |
| 3 | OMEGAT | Даалгавар, асуулгын орчуулга явагддаг орчуулгын программ |
| 4 | MAPLE | Сургууль, сурагчдын түүврийг хийх программ |
| 5 | AMS | Даалгавар кодлох программ |

## 1.2 Даалгавар, асуулга эцэслэх үйл ажиллагаа

2025 оны үндсэн домэйн нь Байгалийн ухааны (хими, физик, биологи, газарзүй) домэйн юм. Математик, унших чадварын хувьд 2022 онд орчуулагдсан даалгавруудаас ашиглаж, цахим орчинд суралцахуйн (ЦОС) инновацлаг домэйн 9 даалгаврыг цогцоор нь орчуулж ашигласан.

Тренд даалгаврын хувьд 2022 оны орчуулгыг хэвээр нь ашигласан бөгөөд дараагийн циклд сурагчдын гүйцэтгэлийг тандах үүднээс ямарваа нэгэн өөрчлөлт хийхийг зөвшөөрдөггүй. 2025 оны циклд зориулж байгалийн ухааны 83 даалгаврыг шинээр орчуулж, 2024 оны 05 сард туршилтын судалгаанд ашиглаж, үр дүнд анализ хийсэн. Үр дүнд орчуулгаас үүдэлтэй байж болох зарим даалгаврын орчуулгыг сайжруулж ACER-ийн холбогдох багт санал хүргүүлж, засварыг оруулж, эцэслэсэн.

Олон улсын үнэлгээний багаас үнэлгээний хэрэгслүүдийг англи болон франц хэл дээр боловсруулдаг бөгөөд улс орнууд өөрсдийн хэл дээр хөрвүүлж, түүнийгээ өөрсдийн нөхцөл байдалд (үг хэллэгийн хувьд) тохируулж, дахин хянуулсны дараа сая эцэслэдэг. Нийт 4-6 үе шатыг дамждаг бөгөөд оруулгыг OmegaT программ дээр хийж, PISA Connect системийн Workflow цэсээр дамжуулан Review/Verification/Technical layout гм. үе шатуудыг дамжин эцэслэдэг.

Зураг 1. Даалгавар, орчуулах, хянах, формат эцэслэх гол алхмууд




4 домэйны даалгавруудыг дээрх байдлаар орчуулж, хянаж, эцэслэсэн бөгөөд дэлгэрэнгүй зураглалыг туршилтын судалгааны өмнөх 2024 он PISA тайлангийн эхний хагас жилийн тайланд үзэх боломжтой.

Эдгээр даалгаврын тоо нь нийт даалгаврын тоо бөгөөд зарим даалгаврууд автоматаар кодлогдоно. Гараар кодлох үйл явцын тайланг энэ тайлангийн 3.1-т үзнэ үү.

Зураг 2. Үндсэн судалгаанд ашиглагдсан даалгавар тоо




2025 оны циклийн үндсэн домэйн нь БУ-ны домэйн тул шинэ даалгавар орж ирж байгаа бөгөөд тренд даалгаврууд юм. Цахим орчинд суралцахуйн даалгавар нь шинэ домэйн тул мөн шинэ даалгавруудаас бүрдэнэ.

Үндсэн судалгааг зохион байгуулах түүвэрт сонгогдсон сургуулиудад зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад PISA 2022 болон PISA 2025 оны асуулга судалгааны онцлог, анхаарах зүйлсийн талаар танилцуулга мэдээллийг бэлтгэн танилцуулж, бэлтгэл хангуулсан.

Зураг 3. Сургалтын танилцуулга мэдээлэл




Зураг 4. Үндсэн судалгаанд ашиглагдсан асуулгын тоо




- ***Сурагчийн асуулга:*** сурагчийн ерөнхий мэдээлэл болон хичээл сургалтын талаар мэдээлэл цуглуулах 78 асуулт, мөн Мэдээлэл Харилцааны Технологийн (МТХ) талаарх мэдлэг ойлголт, хүртээмжийн талаар мэдээлэл цуглуулах 13 асуулт бүхий асуулга судалгааг шалгалтын дараа цахимаар бөглөж, илгээсэн.
- ***Сургуулийн асуулга:*** тухайн улсын боловсролын салбарын талаарх мэдээлэл цуглуулах зорилготой 62 асуулт бүхий асуулга судалгааг сургуулийн Захирал, эсвэл үүрэг хүлээсэн сургалтын Менежер цахимаар бөглөж илгээсэн.
- ***Байгалийн ухааны багшийн асуулга:*** багш (хими, физик, биологи, газарзүй) нарын мэдлэг, чадвар, хандлага, эзэмшсэн боловсрол, хичээл сургалтын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулах 48 асуулт бүхий асуулга судалгааг цахимаар бөглөж илгээсэн.
- ***Эцэг, эхийн асуулга:*** сурагчийн өмнө эзэмшсэн боловсрол болон ар гэрийн орчны талаар мэдээлэл цуглуулах 30 асуулта судалгааг сургуулиас зарласан цагт сургууль дээр ирж, цаасаар бөглөсөн ба хариултуудыг БҮТ-ийн мэргэжилтнүүд системд шивж оруулж, илгээсэн.

Даалгавар эцэслэгдсэний дараа Үндсэн судалгааны бэлтгэл хангах нэгэн чухал алхам нь “Test Assembly/ Candidate Release” буюу шалгалт дэвтэрлэх процесстой зүйрлэж болохуйц, сурагчид оногдох даалгаврын оноолт, багцийг хянах чухал алхам явагдсан. 2025 оны циклийн онцлог нь adaptive/тохируулгат (ихэнхдээ БУ болон математикийн даалгаврууд) болон шугаман хуваарилалттай (ихэнхдээ унших болон ЦОС даалгаврууд) холимог дизайн ашигласнаараа онцлог юм.

Зураг 5. Цахим шалгалт дэвтэрлэх процесс




Сургалт дээр ашиглагдсан слайдын зурагнаас:



| | A | B | C | D | E | F | G | H | I | J | K | L | M |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | test-id | domain | timer | cluster-id-stage1 | cluster-id-stage2h | cluster-id-stage2l | cluster-id-stage3h | cluster-id-stage3mh | cluster-id-stage3ml | cluster-id-stage3l | threshold-stage1 | threshold-stage2h | threshold-stage2l |
| 43 | FLALA2 | FLA | 3600 | LTA002 | LTC104 | LTC101 | LTB204 | LTB203 | LTB203 | LTB201 | 7 | 13 | 13 |
| 44 | FLALA3 | FLA | 3600 | LTA004 | LTC103 | LTC102 | LTB204 | LTB202 | LTB202 | LTB201 | 7 | 13 | 13 |
| 45 | FLALA4 | FLA | 3600 | LTA001 | LTC104 | LTC101 | LTB204 | LTB203 | LTB203 | LTB201 | 6 | 13 | 12 |
| 46 | SA1 | SCI | 3600 | STA006 | STC112 | STC103 | STB215 | STB206 | STB206 | STB203 | 5 | 11 | 7 |
| 47 | SA2 | SCI | 3600 | STA012 | STC115 | STC106 | STB213 | STB208 | STB208 | STB201 | 5 | 9 | 9 |
| 48 | SA3 | SCI | 3600 | STA007 | STC109 | STC107 | STB214 | STB212 | STB212 | STB202 | 5 | 11 | 8 |

| | A | B | C | D | E | F | G | H | I | J | K | L | M |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | test-id | domain | timer | cluster-id-stage1 | cluster-id-stage2h | cluster-id-stage2l | cluster-id-stage3h | cluster-id-stage3mh | cluster-id-stage3ml | cluster-id-stage3l | threshold-stage1 | threshold-stage2h | threshold-stage2l |
| 2 | MA1 | MAT | 3600 | MTA001 | MTB110 | MTB102 | MTC212 | MTC204 | MTC205 | MTC201 | 5 | 13 | 1 |



| Sequence Id | Purpose |
|---|---|
| B001-SA1-MA1 | MSAT implementation science and mathematics (SA1 and MA1) |
| B001-SL1-ML13 | Linear science and linear mathematics (SL1 and ML13) |
| B003-SA2-RA2 | MSAT implementation science and reading (SA2 and RA2) |
| B003-SL2-RB2 | Linear science (SL2) and MSAT implementation reading (RB2) |
| B005-SA45-LDWL9 | MSAT implementation science (SA45) and linear LDW (LDWL9) |
| B005-SA46-LDWL10 | MSAT implementation science (SA46) and linear LDW (LDWL10) |
| B005-SA47-LDWL11 | MSAT implementation science (SA47) and linear LDW (LDWL11) |
| B005-SA48-LDWL12 | MSAT implementation science (SA48) and linear LDW (LDWL12) |
| B005-SL1-LDWL13 | Linear science and linear LDW (SL1 and LDWL13) |
| B005-SL2-LDWL14 | Linear science and linear LDW (SL2 and LDWL14) |
| B005-SL3-LDWL15 | Linear science and linear LDW (SL3 and LDWL15) |
| B005-SL4-LDWL16 | Linear science and linear LDW (SL4 and LDWL16) |
| B005-SL5-LDWL17 | Linear science and linear LDW (SL5 and LDWL17) |
| B005-SL6-LDWL18 | Linear science and linear LDW (SL6 and LDWL18) |
| B005-SL7-LDWL1 | Linear science and linear LDW (SL7 and LDWL1) |
| B005-SL8-LDWL2 | Linear science and linear LDW (SL8 and LDWL2) |
| B005-SL9-LDWL3 | Linear science and linear LDW (SL9 and LDWL3) |
| B005-SL10-LDWL4 | Linear science and linear LDW (SL10 and LDWL4) |
| B005-SL11-LDWL5 | Linear science and linear LDW (SL11 and LDWL5) |
| B005-SL12-LDWL6 | Linear science and linear LDW (SL12 and LDWL6) |
| B005-SL13-LDWL7 | Linear science and linear LDW (SL13 and LDWL7) |
| B005-SL14-LDWL8 | Linear science and linear LDW (SL14 and LDWL8) |
| B005-SL15-LDWL9 | Linear science and linear LDW (SL15 and LDWL9) |
| B005-SL16-LDWL10 | Linear science and linear LDW (SL16 and LDWL10) |
| B005-SL17-LDWL11 | Linear science and linear LDW (SL17 and LDWL11) |
| B005-SL18-LDWL12 | Linear science and linear LDW (SL18 and LDWL12) |
| B005-SL19-LDWL13 | Linear science and linear LDW (SL19 and LDWL13) |
| B005-SL20-LDWL14 | Linear science and linear LDW (SL20 and LDWL14) |
| B005-SL21-LDWL15 | Linear science and linear LDW (SL21 and LDWL15) |
| B005-SL22-LDWL16 | Linear science and linear LDW (SL22 and LDWL16) |
| B005-SL23-LDWL17 | Linear science and linear LDW (SL23 and LDWL17) |
| B005-SL24-LDWL18 | Linear science and linear LDW (SL24 and LDWL18) |
| B005-SL25-LDWL1 | Linear science and linear LDW (SL25 and LDWL1) |
| B005-SL26-LDWL2 | Linear science and linear LDW (SL26 and LDWL2) |
| B005-SL27-LDWL3 | Linear science and linear LDW (SL27 and LDWL3) |
| B005-SL28-LDWL4 | Linear science and linear LDW (SL28 and LDWL4) |




Асуулгын хувьд орчуулга, орчуулгын хяналт зэрэг нь даалгаврын процесстой ижил явагдсан. Асуулга дэвтэрлэх явцад мөн ижил филтерийн нөхцлүүд зөв ажиллаж байгаа эсэхийг тестийн эрхээр ТАО системд хандаж, нягталсан. Ингэхдээ Монгол болон Казах хэлээр аль алинаар нь сурагчийн эрхээр хандаж нягталсан болно.

## 1.1 Түүврийн загвар, сургууль, сурагчдын түүвэр

PISA 2025 судалгааны түүврийн ажил дараах хүрээнд явагддаг.

Зураг 6. Түүврийн даалгаврын ерөнхий алхам



Түүврийн баг  дээрх алхамуудыг гүйцэтгэхдээ NPM-тэй /National Project Manager буюу PISA үнэлгээ хариуцсан БҮТ-ийн мэргэжилтэн/ хамтран зааварчилгаа аван ажилласан. Мөн PISA техникийн стандарт болон ажлын гарын авлагуудад заасан зааварчилгааг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд үйл ажиллагаа бүрийг дор нэгтгэлээ.

Хүснэгт 5. Үйл ажиллагааны нэгтгэл

| № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Огноо/Төлөвлөлт |
|---|---|---|---|
| 1 | PISA /туршилтын болон үндсэн/ үнэлгээнд хамрагдах сургууль, сурагчийн тоог гаргах | Сургууль, сурагчийн эх дата | 2024 оны 12.15-аас 2025 оны 01.15 |
| 2 | Үндэсний хэмжээнд тусгай нөхцөлөөр (илүү тоогоор түүвэрлэх, тусгай хэрэгцээт гм.) түүвэрлэх эсэхийг шийдвэрлэх, зааврын дагуу түүврийн өгөгдлийг бэлдэх | Түүврийн нөхцөлд нийцсэн дата | 2025 оны 02.01-03.01 |
| 3 | Сургуулийн түүврийн өгөгдөлд хяналт тавьж, судалгааны явцад аливаа эрсдэл гарахаас сэргийлэх | Түүврийн эх дата | 03.01-03.06 |
| 4 | PISA үнэлгээнд хамрагдах шаардлага хангасан сурагчдын жагсаалтыг сургууль бүрээс гаргаж, өгөгдлийн чанарыг хангах | Түүвэрлэгдсэн сургуулийн жагсаалт | 03.07-03.14 |
| 5 | PISA ЗБ-аас заасан түүврийн программ ашиглан сургууль доторх сурагчийг түүврээр сонгох | ACER Maple-д ашиглан гаргасан түүврийн дата – сургууль бүрээр | 03.15-03.30 |
| 6 | Өгөгдөл цуглуулж илгээсний дараах PISA ЗБ-аас ирүүлсэн аливаа асуултад хариулах, нэмэлт мэдээлэл өгөх | Судалгааны ЗБ-д хянагч багш нарт зориулсан бүртгэлийн хуудсыг бөглөх заавар | 04.01-04.04 |
| 7 | Туршилтын/үндсэн судалгааны үр дүнг боловсруулах, дата өгөгдөл цэвэрлэх | TAO, MAPLE датаны нийцлийг шалгаж, үр дүн гаргах цэвэрлэсэн дата | 04.20-06.20 |
| 8 | Үндсэн судалгааны эх датаг татаж, эцэслэх | Эх дата | 10.15-10.18 |
| 9 | PISA үндсэн үнэлгээнд  хамрагдах сургууль, сурагч, багшийн датаг бэлтгэх | Сургууль, сурагч, багшийн эх дата | 10.18-10.20 |
| 10 | Үндэсний хэмжээнд тусгай нөхцөлөөр (илүү тоогоор түүвэрлэх, тусгай хэрэгцээт гм.) түүвэрлэх эсэхийг шийдвэрлэх, зааврын дагуу түүврийн өгөгдлийг бэлдэх | Түүврийн нөхцөлд нийцсэн дата | 10.20-11.20 |
| 11 | Сургуулийн түүврийн өгөгдөлд хяналт тавьж, судалгааны явцад аливаа эрсдэл гарахаас сэргийлэх | Түүврийн эцэслэсэн эх дата | 11.20-12.10 |
| 12 | PISA үндсэн судалгааны сурагч, багш, сургуулийн бүртгэлийн формын маягтыг эцэслэх | Бүртгэлийн маягтууд | 12.10-01.01 |
| 13 | PISA үндсэн судалгаанд хамрагдах сургуулийн жагсаалтын хүрээнд шаардлага хангасан сурагчдын жагсаалтыг гаргаж, өгөгдлийн чанарыг хангах үүднээс тухайн сургуулиудын бүх 15 настай сурагчдын нэрсийг баталгаажуулах | Түүвэрлэгдсэн сургуулийн бүх суралцагчдын жагсаалт | 01.02-01.14 |
| 14 | Баян-Өлгий аймгийн суралцагчдын хувьд асуулгыг Монгол болон Казак хэлний сонголттойгоор өгөх тул нэмэлтээр БГ-тай холбогдож, анги тус бүрээр тодруулга авах | Түүвэрлэгдсэн сургуулийн бүх суралцагчдын жагсаалт | 01.02-01.14 |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | PISA ЗБ-аас заасан түүврийн программ ашиглан сургууль доторх сурагчийг түүврээр сонгох | ACER Maple-д ашиглан гаргасан түүврийн дата – сургууль бүрээр | 01.15-02.01 |
| 15 | Өгөгдөл цуглуулж илгээсний дараах PISA ЗБ-аас ирүүлсэн аливаа асуултад хариулах, нэмэлт мэдээлэл өгөх | Судалгааны ЗБ-д хянагч багш нарт зориулсан бүртгэлийн хуудсыг бөглөх заавар | 02.07-02.14 |
| 16 | Үндсэн судалгаанд PISA ЗБ-ын заасан нөхцөлийн дагуу non-reponse bias анализыг хийх | Non-response bias анализ | 04.01-04.14 |
| 17 | Үндсэн судалгааны үр дүнг боловсруулах, дата өгөгдөл цэвэрлэх | TAO, MAPLE датаны нийцлийг шалгаж, үр дүн гаргах цэвэрлэсэн дата | 04.15-06.15 |
| 18 | Хагас жилийн ажлын тайлан боловсруулах | Хагас жилийн тайлан | 06.15-06.30 |

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд алхам бүрээр түүврийн даалгавруудыг гүйцэтгэсэн бөгөөд PISA техникийн стандарт болон даалгавар бүрийн гарын авлага дахь зааварчилгааг баримталсан.

Хүснэгт 6. Түүврийн даалгавруудын агуулга

| Даалгаврууд | Агуулга | Хугацаа |
|---|---|---|
| Даалгавар 0 | Судалгааны хэл | 2022 оны 12-р сар |
| Түүврийн төлөвлөгөө | PISA-2025 түүврийн үйл ажиллагааны төлөвлөгөө | 2023 оны 2-р сар |
| Даалгавар 1 | Туршилт болон үндсэн судалгааг зохион байгуулах хугацаа болон эх олонлог | 2023 оны 4-р сар |
| Даалгавар 2А | Туршилт болон үндсэн судалгаанд хамрагдах сурагчдын мэдээлэл | 2023 оны 11-р сар |
| Даалгавар 2В | Түүврийн нөхцөл | 2023 оны 12-р сар |
| Даалгавар 3/3А | Турших судалгааны дэлгэрэнгүй | 2024 оны 2-р сар |
| Даалгавар 4 | Түүвэрлэгдсэн сургуулийн жагсаалт | 2024 оны 2-р сар |
| Даалгавар 5А/5В | ACER Maple-д оруулах түүврийн датаны баталгаажуулалт | 2024 оны 2-р сар |
| Сургууль доторх түүврийн бэлтгэл | Туршилтын судалгааны Maple-д оруулах түүврийн датаг бэлдэх | 2024 оны 3-р сар |
| Сургууль тодорх түүвэр /ACER MAPLE ашиглах/ | Туршилтад сонгогдсон сургуулийн сурагчдын түүврийг болон сургууль, багшийн мэдээллийг Maple-д оруулах | 2024 оны 4-р сар |
| Даалгавар 6 | Түүврийн датаг баталгаажуулан илгээх | 2024 оны 4-р сар |
| 1 сарын өмнөх сануулга | Үндсэн судалгааны түүврийн төлөвлөгөөт хугацаанаас нэг сарын өмнөх сануулга | 2024 оны 9-10-р сар |
| Pre-form асуултууд | Түүврийн нөхцөлийн баталгаажуулалт | 2024 оны 10-р сар |
| Зөвлөн туслах уулзалт | Westat, Core 3 statisticians багаас зөвлөгөө авах | 2024 оны 10-р сар |
| Даалгавар 7А/7В | Эх олонлог, түүнээс хасах сургуулийн мэдээлэл | 2024 оны 10-11-р сар |

| | | |
|---|---|---|
| Даалгавар 8A | Түүврийн хүрээг тодорхойлсон мэдээлэл | 2024 оны 11-р сар |
| Даалгавар 8B | Түүврийн хүрээ, түүврийн дата | 2024 оны 11-р сар |
| Даалгавар 9 | Түүврийн хуваарилалт болон жижиг сургуулийн анализ | 2024 оны 12-р сар |
| Даалгавар 10A/10B | Үндсэн судалгааны түүврийн жагсаалт | 2024 оны 12-р сар |
| Даалгавар 11A/11B | ACER Maple-д үндсэн судалгааны сургууль доторх түүврийг хийж, баталгаажуулах үйл ажиллагаа | 2025 оны 1-р сар |

Дээрх даалгаврыг гүйцэтгэх явцад ажлын файл болон ACER, Westat багаар хянагдаж, эцэслэгдсэн даалгаврыг тусдаа хадгалж ажиллсан. Мөн түүврийн даалгавар гүйцэтгэх явцад ОУ-ын үнэлгээний байгууллагаас тогтмол зөвлөгөө, чиглүүлэг авч ажилласан.

Зураг 7. Түүрийн даалгаврын ажлын болон үндсэн судалгааны Westat багтай файл солилцох талбар



Зураг 8. Ажлын даалгаврын зөвлөгөө авч буй байдал/жишээ зураг



**Oksana Balabay** *4 weeks ago*

Dear Tseegii,

Hope you are doing well. I have reviewed your forms and still have a couple of questions.

1. ST7A: Compared to the last cycle (2022), I see a 35% increase in the number of 15-year-olds (and a 42.5% increase in the number of enrolled in grades 7 and above). Is this something you'd expect over the course of just 3 years?
2. Please provide links to tables/graphs where the figures/numbers you submit in Q1 and Q2 of ST7A are visible (not just general website addresses). Please save it as a separate table with translated column/row names in case you don't have an English version online and submit it in folder ST7AB on Sharepoint.
3. As for excluding that single religious school, my colleague (John) spoke to Oyunna, and explained that a different national curriculum was not justification for exclusion. She agreed to include the school. If selected, she expected the school would participate (with those few students – is it 17 students you mentioned in category "Other" in Q5.1 of ST7B?). Please update your ST7. This school is still there on your frame in ST8B, right? Please let me know if that's the case. If not, ST8B has to be updated too.
4. Compared to the last cycle, your Khangai region now takes about 6 percentage points less in the structure of your schools (and students) population, but the Central region now has more students in (about 7 percentage points). In terms of schools, both Central and Western regions have about 3 percentage points more each. Is this something you'd expect?
5. Compared to the last cycle, you now have fewer vocational schools (about 2.6 percentage points) and more general schools (about 2.6 percentage points) in the structure of your school population Again, just making sure this is something you'd expect.
6. Please confirm that the National School ID you have provided is artificial and does not have any further meaning within the country that would allow it to be linked back to any actual school identifiers used in your country or educational system.

Kind regards,

Oksana

**Tsetsegdelger Davaanyam** *4 weeks ago*

Dear Oksana

Thank you very much for your suggestions. Please find my responses to your points below:

**Re@1:**
Yes, the current increased number now appears plausible. According to data from the National Statistics Office, there has been about 30% increase over the past three years for 15-years-olds, which aligns with the growth observed in the number of births between 2006 and 2009.

**Re@2:**
To confirm, I'm sharing the link to the official National Statistics Office site. You can view the population by age group there, and we have used the official data for the 15-year-old population as per their records.

https://www.1212.mn/en/statistic/statcate/573051/table-view/DT_NSO_0300_003V1

Here are the birth statistics for reference. https://www.1212.mn/en/statistic/statcate/48171303/table-view/DT_NSO_0300_036V1

**Re@3:**
As per John and your advice, I have updated the ST7 and ST8B files on the SharePoint. In addition, as mentioned earlier, we are sourcing vocational education data from a second source. There was a discrepancy during the last verification, but I can confirm that it has now been corrected.

**Re@4:**
I appreciate your reply. I realized I made a technical mistake earlier, which I have now corrected. There is an estimated 3% difference between the central and western regions, likely due to migration to urban areas.

**Re@5:**

Үндсэн судалгааны эх олонлогийг тодорхойлоход Үндэсний статистикийн хороо[1], Боловсролын мэдээллийн технологийн үндэсний төв[2], Мэргэжлийн боловсролын байгууллагын мэдээллийн сан[3] гэсэн үндсэн гурван эх сурвалжаас 15 настай хүн ам болон одоо суралцаж буй сурагчдын мэдээллийг татаж, нэгтгэсэн. PISA үнэлгээний бүх үйл ажиллагаа техникийн стандартын хүрээнд хийгддэг бөгөөд тус баримт бичгийн 6-р бүлэгт түүврийн үйл ажиллагаатай холбоотой бүх нарийн шаардлагууд бий.

**Standard 6.11 дахь** заалтын хүрээнд хамгийн багадаа 150 сургуулийг түүвэрлэх бөгөөд түүн дээр жижиг сургуулийн анализ дээр үндэслэн сургуулиуд нэмэгдэж, үндсэн судалгаанд хамрагдах сургуулиудыг түүвэрлэдэг.

[1] https://www.1212.mn/en/statistic/statcate/573051/table-view/DT_NSO_0300_003V1
[2] https://www.esis.edu.mn (school year 2024/2025)
[3] https://tvets.edu.mn (school year 2024/2025)

**Жижиг сургуулийн анализ** (Small School Analysis) нь:

- Сонгогдсон бүх сургуулийн PISA сурагчийн тоог харгалзан,
- **TCS-аас бага** буюу 42-оос доош сурагчтай сургуулиудыг шинжлэх үйл ажиллагаа юм.

Техникийн стандартад зааснаар жижиг сургуулиудыг орхигдуулж болохгүй бөгөөд үндсэн судалгаанд түүвэрлэх нь судалгааны хамрах хүрээ, итгэлцүүрийн нарийвчлал, олон улсын харьцуулалтын чанар зэргийг хангахад зайлшгүй шаардлагатай юм. Иймд жижиг сургуулиудыг тусгайлан шинжилж, зөв жин тооцоолох нь PISA 2025 судалгааны чанарын гол нөхцөл билээ. Жижиг сургуулиуд олон байвал, тухайн улс 6300 (эсвэл 5250) сурагчийн шаардлагыг хангахын тулд илүү олон сургууль түүвэрт багтаах шаардлагатай болдог. Жижиг сургууль гэж PISA-д хамрагдах боломжтой сурагчдын тоо нь ердийн түүврийн хэмжээнээс (TCS<42) бага, ялангуяа 25-аас цөөн сурагчтай сургуулийг ойлгоно гэж стандартад заасан байдаг.

Үндсэн судалгааний сургуулийн түүвэр гарсаны дараагаар сургууль доторх түүврийн ажил хийгдсэнээр, **нийт 191 сургуулийн 1343 байгалийн ухааны багш, 7446 сурагч** хамрагдахаар болсон. Улмаар төлөвлөгөөний дагуу үндсэн судалгааны үйл ажиллагаа дууссаны дараа ирцийн мэдээллийг заврын дагуу илгээж, дата цэвэрлэгээний үйл ажиллагаа эхэлсэн. Дараах хүснэгтэд Үндсэн судалгаанд хамрагдсан сургууль, багш, сурагчдын тоог харууллаа.

| **Нийт хамрагдсан сургууль** | **191** | | | | |
|---|---|---|---|---|---|
| Нийт оролцох сурагч | 7446 | Нийт оролцох эцэг эх | 7446 | Нийт хамрагдах багш | 1343 |
| Нийт оролцсон сурагч | 7142 | Нийт оролцсон эцэг эх | 7216 | Нийт хамрагдсан багш | 1329 |
| Нийт ирцийн хувь | 95.9% | Нийт эцэг эхийн хувь | 97% | Нийт ирцийн хувь-Багш | 99.0% |

## 1.2 Холбогдох сургалтууд

Бэлтгэл хангах хүрээнд дараах зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалуудыг танхимаар болон цахимаар зохион байгууллаа.

Хүснэгт 7. БҮТ/ Үндэсний төвөөс зохион байгуулсан сургалтын жагсаалт

| № | Илтгэгч | Оролцогчид/ тоо | | Сургалтын хэлбэр | Сургалтын агуулга | Огноо |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | OECD/ACER | Түүврийн багийн гишүүд | 3 | цахим | MAPLE программд сурагчийн түүвэр хийх аргачлал, системийн танилцуулаг | 01.10 |
| 2 | Үндэсний Төслийн Зохицуулагч /ҮТЗ/ | Үндэсний төвийн гишүүд, хэлтсийн дарга нар | 35 | танхим | 2025 оны төлөвлөгөө, хийгдэх ажлууд | 01.20 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | ҮТЗ/ Тестийн баг, асуулгын баг | Боловсролын Ерөнхий газрын дарга нар | 30 | цахим | PISA үнэлгээний танилцуулга, ач холбогдол, үндсэн судалгааны танилцуулга | 01.21 |
| 4 | ҮТЗ/ Тестийн баг, асуулгын баг | Түүвэрт сонгогдсон 191 сургуулийн менежер, судлагдахууны багш нар | 1600 | 101 ЕБС, МБСБ-танхимаар, 80 ЕБС бүсчилсэн байдлаар цахимаар | PISA үнэлгээний танилцуулга, даалгаврын тавил, оноожуулалт, онцлог 3 домэйн бүрээр | 01.22-01.26 |
| 5 | OECD/ACER | Тестийн багийн гишүүд/ БУ | 8 | цахим | БУ-ны даалгавар бүрийн кодлох аргачлал, дадлага ажил | 01.27-01.30 |
| 6 | ҮТЗ | Тестийн багийн гишүүд | 18 | танхим | Test Assembly/шалгалт дэвтэрлэх алхам-хяналт | 01.29 |
| 7 | OECD/ACER | ҮТҮЗ/ Тестийн багийн гишүүд | 4 | цахим | Үнэлгээ зохион байгуулахад анхаарах зүйлс, бусад орны туршлага | 01.25 |
| 8 | OECD/ACER | Тестийн багийн гишүүд/ математик | 6 | цахим | Математикийн даалгавар бүрийн кодлох аргачлал, дадлага ажил | 02.03-02.05 |
| 9 | OECD/ACER | Тестийн багийн гишүүд/ унших чадвар | 7 | цахим | Уншиж ойлгох даалгавар бүрийн кодлох аргачлал, дадлага ажил | 02.10-02.13 |
| 10 | ҮТЗ/ Асуулгын баг | Комиссын гишүүд/ Хянагч багш | 40 | танхим | Үнэлгээ зохион байгуулах хуваарь, багуудын зохион байгуулалт, гарын авлага, материал, ЭЭАХ асуулга зохион байгуулахад анхаарах зүйлс | 02.24 |
| 11 | ҮТЗ/ IT баг | Комиссын гишүүд/ Тоног төхөөрөмж, сүлжээ хариуцсан мэргэжилтнүүд | 20 | танхим | Компьютер төхөөрөмж, сүлжээний шалгуур, шаардлага, ажиллах алхмууд | 02.25 |
| 12 | OECD/ACER | Асуулгын багийн гишүүд | 4 | цахим | Ажил мэргэжлийн кодлолт, аргачлал, системийн танилцуулга | 02.26 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13 | ҮТЗ/ Асуулгын баг | Үндэсний баг/ асуулга кодлогчид | 8 | танхим | ЭЭАХ асуулга шивэх системтэй танилцах | 04.10 |
| 14 | ҮТЗ | Тестийн баг/ кодлогчид | 16 | цахим | Даалгавар кодлох AMS системтэй танилцах, кодлох зарчим | 05.26 |

### 1.5 Зохион байгуулалтын бэлтгэл үйл ажиллагаа

Түүвэрт хамрагдсан 191 сургуулийн 100 сургууль орон нутагт, 91 сургууль нь нийслэлд байрладаг. Тоног төхөөрөмж, сүлжээний гацалт, аюулгүй байдал, эрсдлийг тооцоолох үүднээс нийслэлд болон аймгийн төвүүдэд үнэлгээг эхэлж зохион байгуулахаар төлөвлөсөн.

БҮТ-с сургууль бүр дээр 2 мэргэжилтэн бүхий 1 баг очиж ажиллах бөгөөд Хянагч багш, Сүлжээний мэргэжилтэн байна. Нийт 20 баг бүрдүүлсэн бөгөөд 40-50 хүн эдгээр багт орж ажиллахаар тооцсон.

Хянагч багшийн хувьд БҮТ болон Боловсролын Ерөнхий Газрын /БЕГ/ мэргэжилтнүүдээс бүрдсэн 20 Хянагч багшийг сургалтад хамруулж бэлтгэсэн. Сүлжээ хариуцсан мэргэжилтнээр БҮТ, БЕГ болон ЕБС-ийн IT багш нарыг гэрээлж, үнэлгээг зохион байгуулав.

БҮТ-с томилогдсон багаас гадна тухайн ЕБС дээр мөн 2 хүнтэй баг гарч ажилласан бөгөөд захирлын тушаалаар томилогдсон.




Үнэлгээ зохион байгуулах маршрутыг сургуулийн байршил, тээврийн хэрэгсэл хүрэх байдал, хугацаа, км зэргийг нарийвчлан гаргаж, харьяа Боловсролын газар, хэлтэстэй ярьж үнэлгээ явагдах огноо, ложистикийг тохирсон.

Зураг 9. Үнэлгээ зохион байгуулах маршрут, хуваарь





2025 оны циклийн зохион байгуулалтын онцлог нь орон нутагт гарах зардал, ложистикийг бүхэлд нь харьяа Боловсролын газар, хэлтэст шилжүүлж ажилласан бөгөөд Боловсролын газрын дарга тушаалаар мөн PISA үнэлгээг хариуцсан баг байгуулж ажилласан нь үр дүнтэй байлаа.

Шалгалт зохион байгуулахад дараах гарын авлага, удирдамжийг боловсруулж хүргүүлсэн байна.

Хүснэгт 8. Боловсруулсан баримт бичгийн жагсаалт

| | |
|---|---|
| 1 | Зохион байгуулагчийн гарын авлага |
| 2 | Хянагч багшийн гарын авлага |
| 3 | Хянагч багшийн зөвлөмж |
| 4 | Үнэлгээний системийн гарын авлага |
| 5 | Компьютер суурьтай үнэлгээний бэлтгэл хангах гарын авлага |
| 6 | Сурагчдын бүртгэлийн маягт |
| 7 | Явцын протокол |
| 8 | Ирцийн хувийг тооцоолох хуудас |
| 9 | Материал хүлээн авах/буцаах маягт |
| 10 | Нууцлалтай материал алга болсон тэмдэглэл |
| 11 | Шалгалт зохион байгуулагчийн тайлан |
| 12 | Багшийн асуулгын нэвтрэх хуудас |
| 13 | Сургуулийн нэвтрэх хуудас |
| 14 | PISA-Үндсэн судалгаа зохион байгуулах удирдамж |

Олон нийт, багш, сурагчдад зориулсан богино хэмжээний шторк, мэдээлэл, ярилцлагын видео бичлэг хийж БҮТ-ийн вэбсайт, олон нийтийн сүлжээнд тавьсан.

Хүснэгт 9. Олон нийтэд таниулцах шторкууд

<table>
<tr>
<td>Шторк 1<br>PISA гэж юу вэ?<br>
</td>
<td>Шторк 2<br>PISA үнэлгээнд хэн хамрагдах вэ?<br>
</td>
</tr>
<tr>
<td>Шторк 3<br>PISA үнэлгээ зохион байгуулагдах хугацаа<br>
</td>
<td>Шторк 4<br>PISA-Сурагчдын мэдлэгийг хэрхэн үнэлдэг вэ?<br>
</td>
</tr>
</table>

| Шторк 5<br>PISA-Асуулга судалгаанд хэн хамрагдах вэ?<br><br> | Шторк 6<br>PISA-Сургууль хэрхэн бэлтгэл хангах вэ?<br><br> |
|---|---|
| Шторк 7<br>PISA-Сурагч хэрхэн оролцох вэ?<br><br> | Шторк 8<br>PISA-Байгалийн ухааны домэйны тухай<br><br> |

Түүвэрт сонгогдон үнэлгээнд хамрагдсан сурагчдад Боловсролын сайд болон БҮТ-ийн захирлын гарын үсэг бүхий ТАЛАРХАЛ гардуулж, PISA үнэлгээний тэмдэг, лого бүхий бал, стикер, утасны наалт дурсгалаа.

Зураг 10. PISA лого бүхий дурсгалын зүйлс

| | |
|---|---|
| <br> |  |
| <br> | <br> |

# 2 ҮНДСЭН СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үндсэн судалгааг 2025 оны 03 сарын 07-ны өдрөөс 05 сарын 07-ны хооронд зохион байгууллаа.

## 2.1 Үнэлгээний хэрэгслийн тухай

Сургууль бүрээс санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 42 хүртэл сурагч ***унших чадвар, байгалийн ухаан, математик болон цахим орчинд суралцахуйн*** (ЦОС), компьютер суурьтай 2 цагийн шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Цахим суурьтай шалгалтаас гадна, сурагч, сургууль, багш (цахимаар) болон эцэг эх, асран хамгаалагчдыг (цаасаар) асуулга судалгаанд хамруулсан.

Шалгалт өгөхөөр түүвэрлэгдсэн ***сурагчид*** шалгалтын дараа үргэлжлүүлэн судалгааны асуулга бөглөх ба тус асуулгыг бөглөхөд 50 минут зарцуулна.Энэхүү асуулгын тайлбарыг дор оруулав.

- Сурагчийн асуулгаар сурагчийн мэдээлэл, ар гэрийнх нь тухай болон сурагч хичээл сургалтдаа хэрхэн ханддаг, амьдралын туршлагынх нь талаар мэдээлэл цуглуулна.
- Мэдээлэл Харилцааны Технологийн (МТХ) талаар хэр мэдлэгтэй нь илрүүлэх асуулга нь сургууль дээр болон сургуулиас гадуур МХТ хэр хүртээмжтэй, МХТ суралцахуйд нь дэмжлэг үзүүлдэг эсэх болон сурагч МХТ-ийн талаар хэр мэдлэгтэйг нь асууж, мэдээлэл цуглуулна. Энэ асуулгыг Сурагчийн асуулгын дараа авна.

***Сургуулийн асуулгаар*** тухайн улсын боловсролын салбарын үйл ажиллагаа хэрхэн явагддаг талаар мэдээлэл цуглуулдаг. Сургуулийн нөхцөл байдал, нөөц боломж, сургуулийн уур амьсгал, багшийн ур чадвар, мэргэжлийн хөгжил, заах арга туршлага, хичээлийн цаг, сургалтын хөтөлбөр, үнэлгээ, үнэлгээний практикийн талаарх мэдээллийг цуглуулдаг. Сургуулийн асуулгыг сургуулийн Захирал онлайнаар бөглөх бөгөөд ойролцоогоор 60 минутын хугацаа шаардагдсан.

***Байгалийн ухааны багшийн асуулгад*** тухайн сургуулийн бүх БУ-ы багш (хими, физик, биологи, газарзүй) нар хичээл сургалтын үйл ажиллагаа, багшийн эзэмшсэн боловсрол, сургалтад хамрагдсан байдал, багшлах туршлагын талаар болон БУ-ы хичээлийг заах арга туршлага, сургалтын орчин, сурагч, сурлагын үр дүнд хандах багшийн хандлага, итгэл үнэмшлийн талаар мэдээлэл цуглуулдаг. Байгалийн ухааны (БУ) багшийн асуулгын хугацаа ойролцоогоор 45 минут байна.

***Эцэг эхийн асуулга нь*** сурагчийн өмнө эзэмшсэн боловсрол болон ар гэрийн орчны талаар мэдээлэл цуглуулан PISA үнэлгээний өгөгдөлд бас нэгэн чухал мэдээлэл нэмэх боломж олгодог. Эцэг эх, асран хамгаалагч асуулгыг цаасаар бөглөх бөгөөд ойролцоогоор 35-40 минут шаардлагатай.

## 2.2 Хяналт мониторинг

PISA үнэлгээний процесс олон улсын стандарт, гарын авлагын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих 2 шинжээчийг OECD/ACER байгууллагаас гэрээлж, ажиллуулсан. 2 шинжээчийг сонгоход Боловсролын Яам, Боловсролын Ерөнхий газар болон Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнд албан бичиг явуулж, тус бүр 2 мэргэжилтний намтар, CV-г PISA Connect сүлжээгээр илгээсэн. Уг 6 мэргэжилтнээс OECD/ACER 2 мэргэжилтнийг сонгож, сургалтад хамруулан, гэрээлж ажиллуулсан.

Ийнхүү БЕГ-с 1, БСҮХ-с 1 шинжээч Хяналт Мониторинг хийж, тус бүр 5-6 сургууль дээр очиж, шалгалтын явцыг ажиглаж, сургалтын менежерээс ярилцлага авч OECD/ACER-т дотоод сүлжээгээр илгээсэн.

Уг шинжээчдээс болон OECD/ACER байгууллагаас процесстой холбоотой аливаа коммент, шүүмж ирээгүй болно.

## 2.3 Зохион байгуулах баг

Шалгалт зохион байгуулахад БҮТ-ийн мэргэжилтнүүд хянагч багшаар ажилласан бөгөөд ЕБС-ийн МТ багш нарыг сургалтад хамруулан Сүлжээний бэлэн байдал хариуцсан мэргэжилтнээр гэрээ хийж ажиллуулсан. Мөн сургууль дээр шалгалт, асуулгыг зохион байгуулах Шалгалт зохион байгуулагч (тухайн сургуулийн сургалтын менежер) болон Мэдээлэл Технологийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтнүүдийг (тухайн сургуулийн МТ багш нар) ажилуулж, нийт **458 хүний** бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.

Хүснэгт 10. Зохион байгуулалтын багийн тоо

| | |
|---|---|
| Шалгалт Зохион байгуулагч буюу тухайн сургуулийн сургалтын менежер | **191** |
| МТ, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн буюу тухайн сургуулийн IT багш | **191** |
| Тоног төхөөрөмж, сүлжээний бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн-БҮТ-с томилогдсон | **12** |
| Хянагч багш- БҮТ-с томилогдсон | **18** |
| Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн-БГ-с томилогдсон | **31** |
| Жолооч, сум дундын-БГ-с томилогдсон | **15** |
| **Нийт** | **458** |

Түүвэрт сонгогдсон сургууль, багш, сурагчид үнэлгээнд идэвхтэй хамрагдаж, орон нутгийн БШУГ-ийн зүгээс мөн дэмжлэг үзүүлж ажиллалаа. Ажлын хэсэг сургууль бүр дээр 2 өдөр ажилласан бөгөөд эхний өдөр сүлжээний бэлэн байдал, 42 компьютер, таблетыг форматлаж бэлдсэн. Мөн эцэг эхийн асуулгыг тухайн өдрөө эхлүүлж 2 дахь өдөр дуусгасан. Сургууль дээр ажилласан 2 дахь өдөр 42 сурагчийн өглөөний ээлжийг 09 цагаас, өдрийн ээлжийг 13 цагаас эхлүүлж, амжилттай зохион байгуулж дуусгалаа.

Хүснэгт 11. Нийт сургуулиудын ирц, оролцоо

| Гарчиг | **Түүвэрлэгдсэн тоо/ ирцийн хувь** |
|---|---|
| Нийт сургуулийн түүвэрлэгдсэн тоо | **191** |
| Нийт түүвэрлэгдсэн сурагчийн тоо | **7446** |
| Нийт оролцсон сурагчийн тоо | **7144** |
| Суралцагчийн ирц | **96%** |
| Нийт оролцсон БУ багш нарын тоо | **1331** |
| Багш нарын ирц | **99%** |
| Асуулга бөглөх эцэг эхийн тоо | **7446** |
| Асуулга бөглөсөн эцэг эхийн тоо | **7216** |
| Эцэг эхийн асуулгын ирц | **97%** |

Зураг 11. Шалгалтын явцын зурагнуудаас



## 3 ДААЛГАВАР, АСУУЛГА КОДЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны 05 сарын 12-ны өдрөөс эхлэн үнэлгээ зохион байгуулалтын дараагийн үе шат буюу дата цэвэрлэх, даалгавар кодлох, эцэг эх асран хамгаалагчийн асуулга кодлох, ажил мэргэжлийг кодлох үйл ажиллагааг эхлүүлсэн.

Зураг 12. Даалгавар, асуулга кодлох, дата цэвэрлэх үе шат, хугацаа



## 3.1 Даалгавар кодлох үйл ажиллагаа

Байгалийн ухааны даалгаврын хариулт кодлох баг нь нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд бүгд БҮТ-ийн албан хаагчид болно. БУ-ны нийт 33 багц 52 шинэ даалгавар болон 17 багц 22 трэнд даалгавар, нийт 50 багц 74 даалгаврын 42232 хариултыг 2025.05.27-06.30-ны хооронд кодолж дуусгасан байна. Нэг кодлогч ойролцоогоор 7040 хариулт кодолсон бөгөөд кодлогчдын дундаж нийцэл 95.36%, анкор 2 кодлогч 2220 хариултыг англи хэл дээр кодолсон бөгөөд дундаж нийцэл 95.34% байгаа нь нэг ойлголттой, гарын авлагын дагуу кодолсонг илтгэж байна.

Нийт 74 даалгаврын 34 нь дундаж нийцэл 92%-д хүрэхгүй байсан бөгөөд эдгээрийг дахин кодлохдоо дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

- Нийцэл унасан 34 даалгавраас 22-ыг тухайн даалгавар дээр хамгийн бага нийцэлтэй байгаа 1-2 кодлогчийн хариултыг устгаж, тухайн кодлогчидтой танхимаар уулзан, зөрүүтэй ойлголтыг нэгтгэн ярилцаж, дахин кодлуулсан.
- Үлдсэн 12 даалгаврыг багаараа устгаж дахин кодолсон. Ингэхдээ цахимаар нэг удаа уулзалт зохион байгуулж, гарын авлага болон нэмэлт тайлбарыг дахин ярилцаж, ойлголтоо нэгтгэн дахин кодолсон.

Математик чадварын кодлох баг нь МУИС-ийн 2 багш, БСҮХ-ийн ЭША 1, БҮТ даалгаврын сангийн 1 мэргэжилтэн 4 хүний бүрэлдэхүүнтэй байсан. Нийт 28 даалгаврын 11243 хариултыг 2025 оны 05-р сарын 27-оос 6-р сарын 16 хүртэл ажлын 13 хоногийн хугацаанд кодолж дуусгалаа. Даалгавар бүрийн кодлох зарчим, хариултын тоо зэрэгт үндэслэн төлөвлөгөө гарган ажилласан. Даалгавар тус бүрийн нийцэл 92%-аас дээш, нийт дундаж 95.96 хувьтай байна.

*Хүснэгт 1 Математик үндсэн судалгааны кодлосон хариултын тоо*

| *№* | *Даалгаврын код* | *Үндсэн хариулт* | *Нийцэл тооцох хариулт нэмэгдсэн тоо* | *Anchor кодлогч.**1*** | *Anchor кодлогч.**2*** |
|---|---|---|---|---|---|
| 1 | CM936Q02 | 534 | 634 | 30 | 30 |
| 2 | CMA119Q03 | 515 | 615 | 30 | 30 |
| 3 | CMA124Q03 | 499 | 599 | 30 | 30 |
| 4 | CM00KQ02 | 481 | 581 | 30 | 30 |
| 5 | CMA158Q03 | 465 | 565 | 30 | 30 |
| 6 | CMA111Q03 | 371 | 471 | 30 | 30 |
| 7 | CM905Q02 | 360 | 460 | 30 | 30 |
| 8 | CM906Q02 | 349 | 449 | 30 | 30 |
| 9 | CM446Q02 | 307 | 407 | 30 | 30 |
| 10 | CMA136Q02 | 301 | 401 | 30 | 30 |
| 11 | CMA127Q02 | 296 | 396 | 30 | 30 |
| 12 | CM462Q01 | 279 | 379 | 30 | 30 |
| 13 | CM954Q02 | 278 | 378 | 30 | 30 |
| 14 | CMA148Q03 | 271 | 371 | 30 | 30 |
| 15 | CMA154Q03 | 269 | 369 | 30 | 30 |
| 16 | CMA110Q03 | 268 | 368 | 30 | 30 |
| 17 | CM992Q03 | 260 | 360 | 30 | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18 | CMA146Q03 | 257 | 357 | 30 | 30 |
| 19 | CM955Q02 | 255 | 355 | 30 | 30 |
| 20 | CMA103Q01 | 239 | 339 | 30 | 30 |
| 21 | CM949Q03 | 227 | 327 | 30 | 30 |
| 22 | CMA149Q03 | 223 | 323 | 30 | 30 |
| 23 | CMA107Q03 | 219 | 319 | 30 | 30 |
| 24 | CMA102Q02 | 216 | 316 | 30 | 30 |
| 25 | CM953Q02 | 213 | 313 | 30 | 30 |
| 26 | CMA142Q02 | 187 | 287 | 30 | 30 |
| 27 | CM953Q04 | 170 | 270 | 30 | 30 |
| 28 | CMA153Q01 | 134 | 234 | 30 | 30 |
| **нийт** | | **7871** | **11243** | **840** | **840** |

Унших чадварын кодлох баг нь БҮТ даалгаврын сангийн 2 мэргэжилтэн, үнэлгээний хэлтсийн 2 мэргэжилтэн, БСҮХ-ийн ЭШ-ний 2 ажилтан нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй даалгавар кодлох ажлыг гүйцэтгэсэн. Нийт 58 даалгаврын 26339 хариултыг 2025 оны 05-р сарын 27-оос 6-р сарын 28 хүртэл ажлын 24 хоногийн хугацаанд кодолж дуусгалаа. Даалгавар бүрийн кодлох зарчим, хариултын тоо зэрэгт үндэслэн төлөвлөгөө гарган ажилласан. Даалгавар тус бүрийн нийцэл 92%-аас дээш, нийт дундаж 95.50 хувьтай байна.

*Хүснэгт 2 Унших чадварын үндсэн судалгааны кодлосон хариултын тоо*

| *№* | *Даалгаврын код* | *Үндсэн хариулт* | *Нийцэл тооцох хариулт нэмэгдсэн тоо* | *Anchor кодлогч.**1*** | *Anchor кодлогч.**2*** |
|---|---|---|---|---|---|
| 1 | CR559Q08 | 1313 | 1413 | 30 | 30 |
| 2 | CR545Q04 | 1248 | 1348 | 30 | 30 |
| 3 | CR543Q15 | 542 | 642 | 30 | 30 |
| 4 | CR456Q02 | 522 | 622 | 30 | 30 |
| 5 | CR219Q01 | 516 | 616 | 30 | 30 |
| 6 | CR456Q06 | 504 | 604 | 30 | 30 |
| 7 | CR446Q06 | 504 | 604 | 30 | 30 |
| 8 | CR563Q12 | 483 | 583 | 30 | 30 |
| 9 | CR542Q02 | 471 | 571 | 30 | 30 |
| 10 | CR566Q12 | 467 | 567 | 30 | 30 |
| 11 | CR570Q10 | 449 | 549 | 30 | 30 |
| 12 | CR563Q09 | 421 | 521 | 30 | 30 |
| 13 | CR553Q04 | 407 | 504 | 30 | 30 |
| 14 | CR460Q01 | 396 | 496 | 30 | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | CR566Q03 | 394 | 494 | 30 | 30 |
| 16 | CR453Q04 | 394 | 494 | 30 | 30 |
| 17 | CR453Q06 | 393 | 493 | 30 | 30 |
| 18 | CR561Q07 | 391 | 491 | 30 | 30 |
| 19 | CR540Q04 | 390 | 490 | 30 | 30 |
| 20 | CR569Q06 | 387 | 487 | 30 | 30 |
| 21 | CR564Q05 | 375 | 475 | 30 | 30 |
| 22 | CR455Q03 | 363 | 463 | 30 | 30 |
| 23 | CR455Q02 | 346 | 446 | 30 | 30 |
| 24 | CR565Q02 | 345 | 445 | 30 | 30 |
| 25 | CR562Q03 | 342 | 442 | 30 | 30 |
| 26 | CR565Q05 | 336 | 436 | 30 | 30 |
| 27 | CR055Q05 | 333 | 433 | 30 | 30 |
| 28 | CR550Q09 | 333 | 433 | 30 | 30 |
| 29 | CR219Q02 | 330 | 433 | 30 | 30 |
| 30 | CR550Q10 | 329 | 429 | 30 | 30 |
| 31 | CR558Q12 | 321 | 421 | 30 | 30 |
| 32 | CR055Q02 | 316 | 416 | 30 | 30 |
| 33 | CR055Q03 | 311 | 411 | 30 | 30 |
| 34 | CR562Q06 | 302 | 402 | 30 | 30 |
| 35 | CR558Q04 | 295 | 395 | 30 | 30 |
| 36 | CR547Q09 | 292 | 392 | 30 | 30 |
| 37 | CR556Q09 | 288 | 388 | 30 | 30 |
| 38 | CR111Q06 | 282 | 382 | 30 | 30 |
| 39 | CR432Q05 | 276 | 376 | 30 | 30 |
| 40 | CR432Q01 | 261 | 361 | 30 | 30 |
| 41 | CR404Q10 | 256 | 356 | 30 | 30 |
| 42 | CR541Q04 | 253 | 353 | 30 | 30 |
| 43 | CR549Q05 | 249 | 349 | 30 | 30 |
| 44 | CR111Q02B | 235 | 335 | 30 | 30 |
| 45 | CR541Q09 | 230 | 330 | 30 | 30 |
| 46 | CR550Q07 | 221 | 321 | 30 | 30 |
| 47 | CR544Q07 | 209 | 309 | 30 | 30 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 48 | CR568Q13 | 204 | 304 | 30 | 30 |
| 49 | CR552Q03 | 198 | 298 | 30 | 30 |
| 50 | CR544Q13 | 193 | 293 | 30 | 30 |
| 51 | CR466Q02 | 193 | 293 | 30 | 30 |
| 52 | CR102Q05 | 179 | 279 | 30 | 30 |
| 53 | CR552Q08 | 178 | 278 | 30 | 30 |
| 54 | CR568Q06 | 178 | 278 | 30 | 30 |
| 55 | CR567Q03 | 168 | 268 | 30 | 30 |
| 56 | CR102Q04 | 151 | 251 | 30 | 30 |
| 57 | CR552Q04 | 138 | 238 | 30 | 30 |
| 58 | CR541Q11 | 138 | 238 | 30 | 30 |
| **нийт** | | **20539** | **26339** | **1740** | **1740** |

## 3.2 Эцэг эх асран хамгаалагчийн асуулга кодлох үйл ажиллагаа

Асуулга кодлох ажилд 9 хүний бүрэлдэхүүнтэй БҮТ-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн баг ажилласан. Нийт ACER Maple систем дээр 7446 түүвэр байснаас 7216 асуулга буюу 97 хувийн хамрагдалттайгаар 5-р сарын 12 өдрөөс эхлэн 6-р сарын 09 өдөр хүртэлх хугацаанд асуулгыг кодолж дуусссан.

Хүснэгт 12. Асуулга кодлолтын багийн ажлын гүйцэтгэл /Хүснэгт 1/

| № | Кодлогч_ID | Кодлосон сургуулийн тоо | Кодлосон асуулгын тоо |
|---|---|---|---|
| 1 | 11 | 19 | 676 |
| 2 | 12 | 20 | 758 |
| 3 | 13 | 25 | 874 |
| 4 | 24 | 24 | 934 |
| 5 | 25 | 23 | 914 |
| 6 | 26 | 23 | 904 |
| 7 | 27 | 27 | 983 |
| 8 | 28 | 27 | 1027 |
| 9 | Кодлолт хариуцагч | 3 | 146 |
| **Нийт** | | **191** | **7216** |

Зураг 13. Кодлох программын харагдах байдал, архивласан байдал




## 3.3 Ажил мэргэжлийг кодлох үйл ажиллагаа

- Үндсэн судалгааны асуулга кодлох арга зүйн цахим сургалтад хоёр удаа хамрагдан, мөн цахим гарын авлага болон монгол улсын ажил, мэргэжлийн кодлолтын стандартыг судалж түүврээр сонгогдон судалгаанд хамрагдсан сурагч, тэдний эцэг, эхийн асуулгын ажил, мэргэжлийн кодлолтыг зааврын дагуу, 3 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж илгээсэн.
- Нийт 16869 ажил мэргэжлийг монгол хэлээр, 109 ажил, мэргэжлийг казах хэлээр кодолж, өгсөн зааврын дагуу 15 хувиар нийцлийг шалгаж, кодлогч хоорондын нийцэл 100 хувьтай гарсан.

Зураг 14. Ажил,мэргэжлийн кодлолтыг хийсэн ажлын хуудас




# 4 ДАТА ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

PISA 2025 үндсэн судалгааны хүрээнд дата цэвэрлэгээний эхний шатын үйл ажиллагааг Үндэсний төв бие даан цуглуулсан бүх өгөгдлийн цэвэрлэгээ, баталгаажуулалтыг гүйцэтгэх ёстой юм. MAPLE-д үндсэн судалгааны багш, сурагч, сургуулийн удирдлагын ирцийг оруулах ажил дууссаны дараа цэвэрлэгээний үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд үндэсний багийн ажиллах ерөнхий хуваарийг дараах зурагт харууллаа.

Зураг 15. Дата цэвэрлэгээний ажлын төлөвлөгөө



### Алхам 1: 2025 оны 6-р сар

Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эхний шатад гүйцэтгэсэн алхамыг дор нэгтгэлээ.




Эхний шат хуваарийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр дуусгаж илгээсэн.

### Алхам 2: 2025 оны 7-р сар

Сурагч, Сургууль болон Багшийн асуулгын хувьд логик зөрүүтэй хэд хэдэн асуултын хувьд тодруулга авах, шинээр кодлуулах саналтай эсэхийг тодруулах, залруулах алхам.

| Асуулга | Логик зөрүү илэрсэн тоо | Шийдвэрлэсэн байдал |
|---|---|---|
| Сургуулийн асуулга | 287 сурагч | Ирүүлсэн гарын авлагын дагуу асуудлыг шинжилж, зарим мэдээллийг ESIS сангаас авах, багш болон сургуулиас нэмэлт тодруулга авах байдлаар засаж кодлох санал хүргүүлсэн, засварлах боломжгүй зарим тохиолдолд хэвээр үлдээхийг зөвшөөрсөн байдлаар хариуг илгээсэн. |
| Сурагчийн асуулга | 11833 | |
| Багшийн асуулга | 213 | |

Дээрх 3 асуулгыг дагалдаж ирсэн pdf гарын авлагад логик зөрүү илэрсэн сурагч, багш, сургуулийн хариултын тоог жагсааж, ямар зөрүү илэрснийг тайлбарлаад уг үндэслэлээр хариултыг хүчингүй /8/, хариулаагүй /9/ гэсэн байдлаар кодлосныг мэдэгдсэн.

8 болон 9 кодоор кодлохыг хүлээн зөвшөөрсөн хариултуудын жишээ: сурагч 7 хоногийн хичээлийн цагийг бөглөөгүй орхисон, БУ, мат, монгол хэлний цаг нь нийт нийлбэр цагаасаа илүү гарсан, 7 хоногт гэрийн даалгаварт зарцуулдаг цагийн тоо нь хэт өндөр/хэт бага, БУ, мат, монгол хэлний нэмэлт сургалтад зарцуулдаг цаг нь нийт нэмэлт сургалтын цагаасаа их гарсан; багшийн туршлагын хувьд 7 хоногт ямар ямар үйл ажиллагаанд ямар цаг зарцуулдаг тухай асуултад логик зөрүү гарсан тул хүчингүй/хариулаагүйд тооцсоныг БҮТ-ийн зүгээс ямар нэгэн засвар, хөндлөнгийн тайлбар хийх боломжгүй тул хэвээр орхисон.

Дахин кодлох буюу хүчингүйд тооцохгүй байх хүсэлтийг дараах төрлийн асуултуудад илгээсэн: сургууль багшийн тоогоо зөрүүтэй өгсөн /ESIS-ээс авсан, захирлаас тодруулсан/, компьютерын тоогоо зөрүүтэй өгсөн /2024.12 сард БҮТ-д ирүүлсэн мэдээлийг ашигласан/,

хөрөнгө оруулалтын тоогоо зөрүүтэй өгсөн /Захирлаас тодруулсан/; сурагчийн асуулга дээр 10-р ангид сурч байгаа хүүхэд 9-р ангийг дүүргээгүй гэж бөглөснийг залруулж кодлуулсан; багшийн асуулга дээр багшийн ажилласан жилийн тоо зөрүүтэй орсон тул тухайн багш нарын логин-ыг авч ESIS-ээс татаж залруулж хүргүүлсэн.

Дата цэвэрлэх, илгээх үйл ажиллагаан Статистикийн албаны мэргэжилтнүүдтэй хамтран гүйцэтгэсэн.

Дата цэвэрлэгээний явцыг БЯ-д танилцуулж, цаашдын чиглэлийг авсан.

Зураг 16. Ажлын файлын жишээ

СУРГУУЛИЙН АСУУЛГА

| Алдаа | Тайлбар | Шалгасан мэдээлэл | Алдаа илэрсэн сургуулийн тоо | Тайлбар | Хариуцах хүн |
|---|---|---|---|---|---|
| check1 | Хүчинтэй хариултын тоо | Системд бүртгэлгүй эсвэл бүх хариулт хоосон байвал "non-administered" (код 7) эсвэл "no-response" (код 9) гэж тэмдэглэнэ | 1 | Дууссан | Батжаргал |
| check3 | SC004-Цахим төхөөрөмж болон сурагчийн харьцаа | Сурагчдын тоо <0, =0, LST-ээс их зөрүүтэй, интернеттэй компьютероос бага тоо гэх мэт FLAG-аар илрүүлсэн | 38 | | |
| check9 | SC261-Цахим төхөөрөмж, программын хурэлцээ, SC004 болон SC261 харьцаа | Компьютер, таблет 0 мөртлөө SC261-д 1%+ хангалт гэж хариулсан эсэх | 1 | | |
| check10 | SC262-Цахим төхөөрөмжийн бодлого, SC004 болон SC262 харьцаа | Нийт төхөөрөмжийн тоо сурагчдаас бага мөртлөө "бүгдэд өгдөг" гэх эсвэл 0 мөртлөө бодлого байгаа гэж хариулсан зөрүү | 52 | | |
| check5 | SC018-Багшийн тоо | Ангиллаар болон нийт дүнгээр багшийн тоо логик зөрүүтэй, 0 эсвэл outlier байвал FLAG | 16 | | Бямбажаргал |
| check6 | SC400-Байгалийн ухааны багшийн тоо | Байгалийн ухааны багшийн тоо, сертификат, мэргэжлийн түвшин, хүйсийн харьцаа, нийт дүнтэй харьцуулан логик шалгалт | 18 | | |
| check7 | SC168-Багш бус ажилтны тоо | 5%-с доогуур эсвэл 95%-с дээш outlier утгуудыг илрүүлсэн | 34 | | |
| check8 | SC200-Хөндлөнгийн үнэлгээ | SC037-д "байхгүй" гэж хариулаад SC200-д "тийм" гэж хариулсан зөрүүг шалгасан | 0 | | |
| check4 | SC016-Төсвийн эх сурвалж | Нийт эх үүсвэрийн хувь 98%-102%-с гадуур эсвэл тооцоолоогүй бол алдаа гэж FLAG | 12 | Дууссан | Цэвээндаш Бадамхатан |
| check2 | SC002-Сурагчийн тоо | Элсэлтийн хэмжээ 0, LST дэх 15 настай сурагчдын тооноос бага, 5%-с доогуур эсвэл 95%-с дээш, эсвэл тооцоолоогүй тохиолдлыг FLAG-аар илрүүлсэн | 21 | Дууссан | |
| check11 | SC042 and SC404 - Хичээл төлөвлөлт болон БУ-ны хичээл төлөвлөлт | Ерөнхий ба байгалийн ухааны хичээл төлөвлөлт хооронд зөрүү байгаа эсэх | 94 | Сургуулийн мэдээлэл ирээгүй учраас сурагчдыг чадвараар ангилсан мэдээллийг засварлах боломжгүй байна. | |
| check12 | SC025-Багшийн мэргэжлийн хөгжил | Нийт багшийн 0% гэх атлаа байгалийн ухааны багш >0% оролцсон гэх зөрүү | 0 | | |
| check13 | SC169/ 170/210-Filter rule | | | | |
| check14 | Үндэсний төвийн дахин кодчилол | | | | |
| | | Нийт | 287 | | |
| | | Нэг хүнд ногдох | 72 | | |

СУРАГЧИЙН АСУУЛГА

| Алдаа | Тайлбар | Шалгасан мэдээлэл | Алдаа илэрсэн сурагчдын тоо | Тайлбар | Хариуцах хүн |
|---|---|---|---|---|---|
| check1 | Хүчинтэй хариултын тоо | Системийн бүртгэл болон хариултын мэдээллийг шалгаж, хоосон эсвэл бүртгэлгүй бол "non-administered" (код 7) эсвэл "no-response" (код 9) | 3 | | Цэцэгдэлгэр |
| check2 | Сурагч, түүний ЭЭАХ-ийн иргэншил, МУ-д хэдэн настайдаа ирсэн тухай(ST021) | MAPLE-ийн нас болон өөрийн мэдүүлсэн ирсэн насыг харьцуулж, ирсэн нас нь одоогийн насаас их бол "invalid" (код 98) | 34 | | |
| check3 | Улиран суралцсан тухай (ST127) | ISCED түвшин 2 мөртлөө ISCED 3 дахин үзсэн гэж мэдүүлсэн тохиолдлыг "invalid" (код 8) | 58 | | |
| check4.1 | 7 хоногт ордог хичээлийн цаг(ST059Q01-Q03) | Шалгалтын хэл, математикийн болон байгалийн ухааны долоо хоногийн цаг 0-75 хооронд байгаа эсэх | 44 (М.хэл), 55 (мат), 50 (БУ) | Дууссан. | |
| check4.2 | 7 хоногт ордог хичээлийн цаг (ST059Q05DA) | Тусгай хичээлүүдийн нийлбэрээс бага эсвэл 10-120 хүрээнээс гадагш байгаа эсэх | 2,836 | | |
| check5 | Нэмэлт сургалтын цаг(ST071Q01, Q05) | Байгалийн ухаан болон бүх хичээлийн цаг 0-50 хүрээнээс гадагш байгаа эсэх | 82 (БУ), 131 (бүх хичээл) | | |
| check6 | Нэмэлт сургалтын цаг болон БУ-ы нэмэлт сургалтын цаг (ST071ба | Байгалийн ухаанд цаг гэж мэдүүлсэн мөртлөө ST502-д "тийм" гэж хариулсан тохиолдлыг "non-administered" (код 7) | 2,804 | | |
| check7 | Гэрийн даалгаварт зарцуулдаг цаг (ST296) | Байгалийн ухаанд зарцуулсан цаг нь нийт бүх хичээлийн гэрийн даалгаврын цагаас их байгаа эсэх | 411 | | |
| check8 | Эзэмших боловсролын түвшин (ST327) | Одоогоор ISCED 3 түвшинд суралцаж байгаа мөртлөө ISCED 2 төгсөөгүй гэж мэдүүлсэн | 366 | | |
| check9 | ST516 асуулгад чиглүүлэх дүрэм хэрэгжээгүй | ISCED 5 ба түүнээс дээш түвшинг төгсөнө гэж мэдүүлсэн мөртлөө ST516-д хариулсан | 4,959 | | |
| check10 | Үндэсний төвийн дахин кодчилол | | | | |
| | | Нийт | 11833 | | |

БАГШИЙН АСУУЛГА

| Алдаа | Тайлбар | Шалгасан мэдээлэл | Алдаа илэрсэн багшийн тоо | Хариуцах хүн |
|---|---|---|---|---|
| check1 | Хүчинтэй хариултын тоо | Багшийн асуулгын хариулт огт байхгүй эсвэл хүчинтэй өгөгдөлгүй эсэхийг шалгасан. | 0 (1331 багш бүгд бүртгэлтэй, хүчинтэй өгөгдөл) | Оюунчимэг |
| check2 | Багшийн нас (TC002) | Нас нь боломжит доод хязгаараас (15 нас) бага эсэх. | 5 (15-аас бага нас илгээсэн) | |
| check3 | Багшийн ажил эрхлэлт (TC261) | "Энэ сургуульд" ажиллах цагийн хувь нь "бүх ажил эрхлэлтийн нийлбэр"-ээс их байгаа эсэх. | 18 | |
| check4 | Багшийн туршлага (TC007) | 1) "Энэ сургуульд ажилласан жил" нь нас-15-аас их, 2) "Энэ сургуульд ажилласан жил" нь "нийт ажилласан жил"-ээс их, 3) "Нийт ажилласан жил" | 4 (нас-15-аас их), 22 ("энэ сургууль" > "нийт"), 7 | |
| check5 | Сүүлийн 7 хоногт ямар хугацаа зарцуулсан тухай | Бүх дэд асуултуудын (TC216Q01-TC216Q08) 0-90 цагийн хязгаараас хэтэрсэн эсэх. | Q1: 37, Q2: 23, Q3: 18, Q4: 23, | |
| check6 | Үндэсний төвийн дахин кодчилол | | | |
| | | Нийт давхардсан тоогоор | 213 | |






| School name | Esis id | Sum of Дэмжлэг | Sum of Сэтгэл зүйч, | Sum of Угтагч, нарийн бичи | Sum of Менежмент | Төрөл | Аймаг, дүүрэг | Өмчийн хэлбэр | Анхны сурагчдын то | Анхны багшийн то | Анхны түүврийн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сэлэнгэ аймгийн Орхон сумын Ерөнхий боловсролын сургууль | 40249 | 0 | 3 | 0 | 6 | General | Сэлэнгэ аймаг | Төрийн өмчийн | 23 | 2 | 23 |
| Нийслэлийн ерөнхий боловсролын Оюуны-Эрин сургууль | 40194 | 0 | 10 | 4 | 11 | General | Нийслэл-Багануур дүүрэг | Төрийн өмчийн | 99 | 6 | 42 |
| Нийслэлийн ерөнхий боловсролын далан тав дугаар сургууль | 39952 | 2 | 2 | 0 | 4 | General | Нийслэл-Хан-Уул дүүрэг | Төрийн өмчийн | 161 | 9 | 42 |
| Нийслэлийн ерөнхий боловсролын нэг зуун арван найм дугаар сургууль | 40147 | 4 | 6 | 10 | 11 | General | Нийслэл-Хан-Уул дүүрэг | Төрийн өмчийн | 165 | 5 | 42 |
| Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургууль | 39679 | 2 | 2 | 1 | 4 | General | Булган аймаг | Төрийн өмчийн | 67 | 12 | 42 |
| Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын Орхон сургууль | 39862 | 0 | 4 | 4 | 6 | General | Өвөрхангай аймаг | Төрийн өмчийн | 82 | 9 | 42 |
| Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль | 39848 | 2 | 4 | 1 | 4 | General | Өвөрхангай аймаг | Төрийн өмчийн | 161 | 22 | 42 |
| Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэм сургууль | 39740 | 0 | 3 | 2 | 4 | General | Баянхонгор аймаг | Төрийн өмчийн | 82 | 11 | 42 |
| Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль | 40178 | 3 | 4 | 0 | 6 | General | Баян-Өлгий аймаг | Төрийн өмчийн | 111 | 13 | 42 |

## Алхам 3: 2025 оны 9-р сар

Танин мэдэхүйн даалгаврын хувьд ахин хянах шаардлагатай гэж үзсэн 132 даалгавар /БУ, математик болон унших чадвар/-ын гүйцэтгэлийн статистик ирсэн бөгөөд даалгаврын хүндрэл, ялгах чадвар, хамаарал, нийцлийн хувьд ОУ-ын тоон статистикаас зөрсөн, ялгаатай, анхаарал татахуйц өгөгдлийг иргүүлж, Даалгаврын баг хянасан.

Зураг 17. Даалгаврын дата чек








| | | | | |
|---|---|---|---|---|
| Mathematics | CM803Q01 | | No Action: No issues in terms of formatting and layout. However, for further reference, this reply might be more suited for manual coding. The Question does state how many, however students might have entered correct answers in fraction, or in percenatage. | |
| Mathematics | CM905Q02 | | | |
| Mathematics | CM909Q01 | | | |
| Mathematics | CM949Q03 | | | |
| Mathematics | CM954Q02 | | | |
| Mathematics | CM954Q04 | | | |
| Mathematics | CM955Q03 | | | |
| Mathematics | CMA111Q03 | | | |
| Mathematics | CMA114Q04D | | | |
| Mathematics | CMA119Q03 | | | |
| Mathematics | CMA120Q02T | | | |
| Mathematics | CMA128Q02D | | No action: However, for future reference, there were translation and layout issue. Some wordings are in different language, probably kazakh language. Marked in yellow. | |
| Mathematics | CMA144Q01 | | Delete: Translation and layout issue. Some wordings are in different language, probably kazakh language. Marked in yellow. However, it seems not to affect student performance. | |

Дээрх үзүүлэлтээр ОУ-ын дунджаас ямар нэгэн байдлаар зөрүүтэй байгаа тохиолдолд даалгаврын эхийг хянаж, орчуулгын, эсвэл харагдах байдал форматын асуудал байгаа эсэх, даалгавар нь ойлгомжтой байгаа эсэхийг ахин хянаж коммент бичиж илгээсэн.

## Алхам 4: 2025 оны 11-р сар

Нийт 4 асуулгын бүх хариултын /сургууль, сурагч, багш болон эцэг эхийн асуулга/ датаг excel болон SPSS файлаар хүлээн авч танилцсан бөгөөд хариултын логик алдаа, зөрүү байгаа эсэх, уг зөрүү нь орчуулгын болон форматын ямар нэгэн алдаанаас үүдэлтэй байж болох эсэхийг хянаж, фийдбак илгээсэн.

Оролцогчдын 5%-с дээш нь хариултаагүй хоосон орхисон тохиолдол онцгойлон хянасан бөгөөд эдгээр нь ихэнхдээ “мөр бүрт бөглөнө үү” гэснийг харалгүй зөвхөн өөрт хамаарах нэг хариултыг сонгосон тохиолдлууд байсан. Харин зарим хариултын хувьд цаанаас ирсэн excel дээрх хариултын дараалал SPSS дээрхтэй зөрсөн, эсвэл сөрөг үгээр илэрхийлэгдснэ хариултын label-ийг зөрүүлж тавиагүй зэрэг зөрүү гарсныг зааврын дагуу коммент оруулж илгээсэн.



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ST125 | Go to ST125 | | How old were you when you started <ISCED 0>? | No Issue | |
| ST127 | Go to ST127 | Yes | Have you ever repeated a <grade>? | No Issue | |
| ST226 | Go to ST226 | | How long have you been enrolled at this school? | No Issue | |
| ST062 | Go to ST062 | | In the last two full weeks of school, how often did the following things occ | Data issue | It seems to be negative worded question. Kindly advise if the labels need to be reversed? Xls and SPSS files are showing the same. |
| ST034 | Go to ST034 | | Thinking about your school: to what extent do you agree with the followin | Data issue | On this xls file:ST034Q02TA, ST034Q03TA, ST034Q05TA showing incorrect label/frequency order. On SPSS: All questions are showing corre |
| ST038 | Go to ST038 | | During the past 12 months, how often have you had the following experie | No Issue | |
| ST265 | Go to ST265 | | To what extent do you agree or disagree with the following statements? | Data issue | On this xls file: all showing correct label order, BUT incorrect frequency. On SPSS: All questions are showing correct label order, and frequ |
| ST097 | Go to ST097 | | How often do these things happen in your <school science> lessons? | No Issue | |
| ST100 | Go to ST100 | | How often do these things happen in your <school science> lessons? | Data issue | On this xls file: all showing correct label order, BUT incorrect frequency. On SPSS: All questions are showing correct label order, and frequ |
| ST104 | Go to ST104 | | How often do these things happen in your lessons for this <school science | No Issue | |
| ST469 | Go to ST469 | | This school year, how often did your teacher do the following things in you | No Issue | |
| ST468 | Go to ST468 | | This school year, how often did your teacher do the following things in you | No Issue | |
| ST531 | Go to ST531 | | When learning <school science> topics at school, how often do the followi | Data issue | On this xls file: all showing correct label order, BUT incorrect frequency. On SPSS: All questions are showing correct label order, and frequ |
| ST094 | Go to ST094 | | How much do you disagree or agree with the statements about yourself be | No Issue | |
| ST129 | Go to ST129 | | How easy do you think it would be for you to perform the following tasks c | Data issue | On this xls file: all showing correct label order, BUT incorrect frequency. On SPSS: All questions are showing correct label order, and frequ |
| ST131 | Go to ST131 | | How much do you disagree or agree with the statements below? | Data issue | On this xls file: ST131Q17TA showing correct label order, BUT incorrect frequency. On SPSS: All questions are showing correct label order, |
| ST501 | Go to ST501 | | How much do you agree or disagree with the following statements? | No Issue | Энэ жаахан доогуур үзүүлэлттэй гарсан байна. 2022 дээр байгаа эсэхийг шалгах |
| ST495 | Go to ST495 | | How often have you been involved with the following activities in the last | No Issue | |
| ST496 | Go to ST496 | | Below are possible reasons why you would not have participated to activit | Data issue | It seems to be negative worded question. Kindly advise if the labels need to be reversed? Xls and SPSS files are showing the same. |
| ST499 | Go to ST499 | | How strongly do you agree with the following statements? | No Issue | |
| ST500 | Go to ST500 | | How much do you agree with the following statements about environmen | No Issue | |
| ST498 | Go to ST498 | | In the past 12 months how often have you done the following activities? | No Issue | |
| ST092 | Go to ST092 | | How informed are you about the following environmental issues? | No Issue | |
| ST059 | Go to ST059 | | How many <class periods> per week are you typically required to attend fo | No Issue | |
| ST071 | Go to ST071 | Yes | This school year, approximately how many hours per week do you spend l | No Issue | checked, NO ISSUE |
| ST502 | Go to ST502 | Yes | This school year, which types of additional <School science> instruction do | No Issue | Only the NA questions are flagged here. ST071 seems to be filter question, and about 6443 student have replies that they attend Science |
| ST296 | Go to ST296 | Yes | In a typical school week, approximately how much time do you spend on h | No Issue | |

Тайлан боловсруулсан:
Чанарын болон олон улсын үнэлгээний ахлах мэргэжилтэн
Э.Оюунчимэг

Үндэсний багийн гишүүд

| д/д | Албан тушаалын нэр | Багийн ахлагч |
|---|---|---|
| 1 | Үндэсний төслийн зохицуулагч | Э.Оюунчимэг |
| 3 | Судлагдахуун болон агуулга хариуцсан менежер | С.Гэндэнжамц |
| 5 | Түүврийн багийн гишүүд | Д.Цэцэгдэлгэр Х.Бадамхатан<br>П.Бямбасүрэн |
| 6 | Дата өгөгдлийн багийн гишүүд | М.Цэрэнцоодол<br>А.Цэвээндаш |
| 7 | Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн | З.Алтансүх<br>Э.Мөнхжаргал |
| 8 | Дэмжих багийн гишүүд | И.Санаасайхан<br>У.Мөнх |
| 9 | Тестийн багийн гишүүд /байгалийн ухаан | Б.Жаргал<br>А.Даваадулам<br>З.Лхагвадулам<br>М.Сумъяагэрэл<br>Л.Очирсүх |
| 10 | Тестийн багийн гишүүд /математик | М.Бямбасүрэн<br>А.Ганчимэг<br>Х.Нацагдорж<br>Г.Түмэнбаяр<br>А.Баяржаргал |
| 11 | Тестийн багийн гишүүд /унших | Т.Отгон-Эрдэнэ<br>М.Өсөхбаяр<br>Н.Отгонзул<br>Х.Тунгалагтуул<br>Д.Энхжаргал<br>Б.Оюунцэцэг<br>Х.Отгонбаатар |
| 12 | Тестийн багийн гишүүд /цахим орчинд суралцахуй | Э.Алтантулга |
| 13 | Асуулга, логистикийн багийн гишүүд | Р.Ундрахбаяр<br>Д.Янжинжав<br>Б.Батжаргал |